



Хөрөнгийн зах зээлд оролцогч таны хөтөч

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Эрхэм зорилго: Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгээр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.



ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ГАРЫН  
АВЛАГА

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТУХАЙД

Монголын хөрөнгийн бирж / МХБ/ нь Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үе шатанд Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах зорилгоор 1991 онд үүсгэн байгуулагдсанаас хойш өдгөө 23 дах жилийн нүүрийг үзэж байна.

2010 оноос эхлэн Монголын хөрөнгийн зах зээл бүрэн сэргэж МХБ-ийн арилжааны идэвх эрс сайжирсаар байна 2011-2012 онд нийт 3 компани өөрийн хувьцааг анхдагч зах зээл дээр санал болгож 22.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг МХБ дээр босголоо. Олон жилийн турш дурьдагдаагүй байсан компанийн бонд сэргэж, "Жаст Арго" ХХК 4.4 тэрбум төгрөгийн компанийн бонд гаргаж амжилттай арилжаалсан юм.

Монгол Улсын Засгийн Газрын өөрийн бодлогын хүрээнд дэх төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор нийт 236.7 тэрбум төгрөгийн ЗГ-ын бондыг МХБ-ээр дамжуулан амжилттай арилжаалж өөрт шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлсэн зэргээс хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан дотоодын эрэлт хэрэгцээ, нөгөөтэйгүүр түүнд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын сонирхол их байгаа нь илэрхий билээ.

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ

Компаниуд яагаад үнэт цаас гаргадаг вэ?

- ✓ Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх өөр компанийг худалдан авах ажиллагааг санхүүжүүлэх;
- ✓ Компанийн нэр хүнд харилцагч, хэрэглэгч, нийлүүлэгч, хөрөнгө оруулагч болон хэвлэл мэдээллийнхний хүрээнд өсгөх;
- ✓ Өөрийн бизнесийн үнэ цэнийг зах зээлд бодит оор үнэлүүлэх;
- ✓ ХХК-ийн хувь эзэмшигч талууд бизнесээс гарах;
- ✓ Ирээдүйд хөрөнгө босгох үйл явцыг хялбаршуулах;
- ✓ Компанийн удирдах албан тушаалтнууд болон ажилтнууддаа хувьцаа эзэмшүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх;
- ✓ Хүссэн үедээ зах зээлд нэвтэрч, үнэт цаасаа арилжаалах боломжтой;

Үнэт цаас гаргах нь дараах давуу талуудыг бий болгодог:

- ✓ Санхүүжилтийн эх үүсвэр

Компаниа өргөжүүлж хөгжүүлэх төслийг санхүүжүүлэх их хэмжээний эх үүсвэрийг бага зардлаар татан төвлөрүүлэхээс гадна ирээдүйд нэмэлт санхүүжилт татан ажиллагаа нь хялбаршуулж цаг хугацааг, зардал хэмнэнэ.

Бусад санхүүгийн эх үүсвэр авахтай харьцуулбал үндсэн болон хүүгийн төлбөрийн дарамт байхгүй.

- ✓ Зах зээлийн үнэлгээ нэмэгдэх

Компанийн үйл ажиллагаа, ирээдүйтэй холбогдох бүх мэдээллээс хамаарч компанийн үнэлгээ зах зээлийн ханшаар өндрөөр тогтоогдох боломжтой.

- ✓ Олон нийт болон хөрөнгө оруулагчдад танигдах

Үнэт цаас гаргасан компаниуд нь хэвлэл мэдээллийн анхааралд илүү өртдөг төдийгүй зах зээлийн индексийн багцад орж тооцогдох боломжтой тул тухайн компани болон компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийт таньж мэдэх боломжтой.

- ✓ Үнэт цаасны арилжааны хоёрдогч зах зээл

Компанийн үнэт цаас анх гарсны дараа хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж эхлэх тул компанийн хувьцаа эзэмшигч хүссэн үедээ өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдах боломжтой.

Дотоод гадаадын хувь хөрөнгө оруулагчид болон институцийн хөрөнгө оруулагчидтай цаашид хамтран ажиллаж нэмэлт хөрөнгийг босгоход хялбар болно;

МХБ-д үнэт цаас гаргах давуу тал

- ✓ Дэлхийн анхаарлын төвд оршиж буй зах зээлийн нэг хэсэг болох боломжтой юм. Уул уурхайн үсрэнгүй хөгжлийг дагаад монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд асар хурдацтай өсч, ДНБ 2010 онд 6 % байснаас 2011 онд 17 % -д хүрч өссөн нь дэлхийн анхаарлыг татаж буй өнөө цагт Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, тэдний хөрөнгийн урсгал нэмэгдсээр байна.
- ✓ Гадаадын зах зээлтэй харьцуулбал үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбогдон гарах зардлууд хямд тусахаас гадна орон зай, цаг хугацаанаас үүдэлтэй үйл явц удаашрах эрсдэлээс сэргийлнэ.
- ✓ МХБ нь дэлхийн хамгийн том индексүүдийн нэг Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE индексийг эх орондоо нутагшуулаад байгаагаар холбогдуулан бүртгэлтэй компаниуд нь FTSE-ийн Монголын зах зээлийн индексийн багцад орох боломжтой. Зөвхөн индексэд багтсан компаниудад хөрөнгө оруулдаг гадаадын маш олон хөрөнгө оруулалтын сангууд байдаг тул танай компанийн үнэт цаасыг худалдан авах эрэлт маших байна.
- ✓ Монголын хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин таатай болж, нарийн судалгаа шинжилгээн дээр тулгуурлан хууль, дүрэм, журмуудыг олон улсын стандартын дагуу шинэчлэн баглагдаж, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн арилжааны системийг нутагшуулан төлбөр тооцооны Т+3 аргачлалыг нэвтрүүлснээр зах зээлийн ерөнхий механизмыг олон улсын стандартад нийцүүлж чадсан.
- ✓ МХБ нь дэлхийд тэргүүлэгч Лондонгийн хөрөнгийн бирж групптэй урт хугацаанд стратегийн түвшинд хамтран ажиллах болсноор

МХБ-д бүртгэлтэй компаниуд Лондонгийн хөрөнгийн биржид давхар бүртгүүлж өөрт шаардлагаг ахиуц хөрөнгийг татан төвлөрүүлэх боломжоор хангагдаж байна.

## ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШАЛГУУР, ШААРДЛАГА

Үнэт цаас гаргаж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхийн тулд үнэт цаас гаргагч нь холбогдох хууль дүрэм, журамд заасан шалгуур, шаардлагыг хангах ёстой. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагууд:

### Үнэт цаас гаргагчдын хувьд:

- Монгол улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нийт гаргасан үнэт цаасныхаа 90% буюу түүнд суурилсан хадгаламжийн бичгээ гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлж арилжаалж болно.
- Нийтэд санал болгон анх удаан хувьцаа гаргах компани нь:
  - Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
  - Үйл ажиллагаа явуулсан жил, өөрийн хөрөнгийн дундаж өгөөжид тавигдах шаардлагыг хангасан байх.

| ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ  |
|---|
| ➤ <u>Өргөдөл</u> / Гадаад улсын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржид бүртгүүлэх тухай/   |
| ➤ <u>Шийдвэр хүргүүлэх</u> / Гадаад улсын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржид тухайн компанийн үнэт цаасыг бүртгэсэн тухай шийдвэр/               |
| ➤ <u>Танилцуулга</u> /Гадаад улсын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржид бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулга/                                       |
| ➤ <u>Тайлан</u> /Гадаад улсын үнэт цаасны анхдагч зах зээлд арилжаалагдсан үнэт цаасны хэмжээ, үнэ, зах зээлээс татсан хөрөнгийн нийт дүнгийн тухай тайлан/ |

Улс орны эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт хөгжилд бодигой хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл, үйлчилгээний **Төсөл хэрэгжүүлэхээр байгуулагдсан компанид** дээрх шаардлага хамаарахгүй бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Төсөл цаашид тогтвортой хэрэгжихэд шаардлага санамж бичиг, гэрээ, хэлцлийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч нартай байгуулсан;
- Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авсан;
- Андеррайтераар хүлээн зөвшөөрөгдсөн төслийн техник эдийн засгийн үндэслэлтэй байх;
- Компанийн эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;
- Компанийн засаглалын журмуудыг боловсруулж батлах

### МХБ-ИЙН БҮРТГЭЛ ШАЛГУУР, ШААРДЛАГУУД

| ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ   | ҮНДСЭН ЗАХ   | ТУСЛАХ ЗАХ                 |
|--|--|----------------------------|
| <b>Үнэт цаас гаргагчид тавих шалгуур</b>   |  |                            |
| Компанийн засаглалын зарчим  | Дагаж мөрддөг байх   | Дагаж мөрддөг байх         |
| Үйл ажиллагаа явуулсан жил   | 3-аас доошгүй  | 1-ээс доошгүй жил          |
| Санхүүгийн тайлан  | Сүүлийн 3 жилийг аудит лагдах, IFRS /GAAP аль нэгээр тайлагнах | 1 жилийн санхүүгийн тайлан |
| Зуучлагч буюу андеррайтер  | Байх /заримдаа шаардахгүй/                                     | Байх шаардалагтай          |
| Гүйцэтгэх удирдлага нь туршлагатай байх, Хяналтын эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан хугацаа хэтэрсэн өргүй байх          |  |                            |
| сүүлийн 3 жилийн дотор компанийн удирдлагын баг, сүүлийн 1 жилд нөлөө бүхий хувь эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй байх |  |                            |

#### Шалгуурууд:


\* Улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг дэд бүтцийн болон стратегийн чухал ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ХК-ийн үнэт цаасыг бүртгэлийн тусгай шалгуураар бүртгэнэ.

#### Шаардлагууд:

- Олон улсын хүлээн зөвшөөрсөн аргачлал удирдамжийн дагуу өөрийн компанийн засаглалын журам, дүрмийг батлан мөрдөнө.
- Санхүүгийн тайлан, үнэт цаасны гүйлгээ, үнэ ханш, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээ, компанийн болон удирдлагын үйл ажиллагааны талаар мэдээллийг олон нийтэд болон МХБ-д шударга, шуурхай, илтөд хүргэнэ.
- Үнэт цаас хариуцсан ажилтантай байна.

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд олон нийтэд зарлан хуралдуулах ба хурлаар хэлэлцэх асуудал, хурлын материал, шийдвэрийг гэрээнд заасан хугацаанд МХБ-д ирүүлнэ.

## ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ҮЕ ШАТ



## МХБ-Д БҮРТГҮҮЛЭХ ҮЕ ШАТ

МХБ-д бүртгэлтэй шалгалт хийгдах, бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах

МХБ-ийн Бүртгэлийн албанд шалгалт хийгдэж, бүртгэх эсэх тухай асуудлыг Захирлын Зөвлөлийн Хурлаар оруулан хэлэлцэж, Гүйцэтгэх захирал шийдвэр гаргана.

20

Монголын хөрөнгийн биржид хүсэлт гаргах

МХБ-ийн бүртгэлтэй компанийн болон үнэт цаасны жагсаалтад үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт, өргөдлийн хамт “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу баримт материал бүрдүүлэн ирүүлэх./дэлгэрэнгүйг [www.mse.mn](http://www.mse.mn)-

1 өдөр

Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулж бүртгэлтэй компанийн эсвэл бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэнэ

МХБ-д бүртгэлтэй шалгалт хийгдах, бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах


- МХБ-ээс “ҮЦТТХТ” ХХК-д үнэт цаас хадгалах мэдээлэл хүргүүлнэ.
- Үнэт цаас гаргагч нь “ҮЦТТХТ” ХХК-тай “Хадгаламжийн гэрээ”-г байгуулна

1 сар

Үнэт цаасаа арилжих


- Үнэт цаасны арилжааг тогтоосон аргын дагуу зохион байгуулж, явуулна.





Бэлтгэл

Гүйцэтгэл



Preparation

Execution

## ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Хувьцаат компани нь өөрийн олон улсын хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж, МХБ-д бүртгэлтэй хэвээр байхын тулд Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ,МХБ-ийн холбогдох дүрэм, журам, заавруудыг мөрдөх үүргийг хүлээнэ.

Үнэт цаасны бүртгэлийн шаардлага үргэлжлүүлэн хангах

Компани нь үнэт цаасаа бүртгүүлэхийн тулд үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангах ёстой бөгөөд бүртгэлтэй байх хугацаанд эдгээр шалгуур, шаардлагыг тогтмол хангах үүрэгтэй

Мэдээллийг олон нийтэд нээлттэй, илт оод, шуурхай хүргэх

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнэ ханш, тоо хэмжээ, арилжааны идэвхид нөлөөлж болохуйц бүх мэдээ мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагтай. / СЗХ-ны “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам” болон “Бүртгэлтэй компаниуд цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-ыг харна уу /

Санхүүгийн тайлан, мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнах

Хагас жилийн болон аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль –д заасан хугацаанд гарган хүргүүлэх, тайлангийн хураангуйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх

Компанийн сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх

Хувьцаат компаниуд нь Монголын компанийн засаглалын кодекст-т нийцүүлэн дот оод дүрэм журмаа боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөнө.

Хувь нийлүүлэгчдийн хурал зарлан хуралдуулах

Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах ба хурлаас гарсан шийдвэр тэмдэглэлийг СЗХ болон МХБ-д ирүүлнэ.

Ногдол ашиг тараах эсэх

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргах ба ногдол ашиг хуваарилахаар шийдсэн тохиолдолд хугацаандаа хуваарилах, хуваарилахгүй тохиолдолд хугацаандаа шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВЛӨГӨӨГ ХААНААС АВАХ ВЭ?

Энэхүү танилцуулгаас та бүхэн үнэт цаас гаргах шаардлага, ач холбогдол, дотоодын хөрөнгийн зах зээлээс шаардлагтай хөрөнгөө татан төвлөрүүлэх үе шат, тавигдах шалгуур, шаардлага, үнэт цаас гаргасны дараа тогтмол биелүүлэх үүрэг зэрэг мэдээллийг олж авлаа.

Үнэт цаас гаргаснаас компани нь өөрт шаардлагтай хөрөнгийг татан төвлөрүүлэх, цаашид хөрөнгө татан төвлөрүүлэх ажиллагааг хялбарчлах, компанийн нэр хүндээ өсгөх, бизнесийн үйл ажиллагаагаа бодитой үнэлүүлж үнэ цэнийг өсгөх гэх зэрэг маш олон давуу талуудыг өөртөө бий болгодог бөгөөд компанийн засаглалаа сайжруулж олон нийтэд нээлттэй ил тод ажиллах үүрэг хүлээдэг билээ.

Хөрөнгийн зах зээлийн санал болгож буй эдгээр давуу талуудыг өөртөө бий болгож, үнэт цаасаа олон нийтэд санал болгохыг хүссэн аливаа компани нь МХБ-ийн гишүүн андеррайтерийн компаниудаас/ андеррайтерийн компаниудын жагсаалтыг МХБ-ийн цахим хуудас [www.mse.mn](http://www.mse.mn) –ээс харна уу / зөвлөгөө авахаас гадна МХБ-ийн Анхдагч зах зээлийн албанд хандаж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК

Анхдагч зах зээлийн алба

Холбоо барих хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Чингис хааны талбай -3

Утас: (+976)-11-313511-(142); Факс: (+976)-11-325170

Вэб хуудас: [www.mse.mn](http://www.mse.mn); И-мэйл: info@mse.mn.